

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

| | | | |
|-----------------------------------------------------|-----------------------------------------------------------------|---------------------|----------------|
| Ярилцлага өгөгчийн нэр | Гаржүдийн Диваасамбуу | Дугаар | L014 |
| Оршин суугаа аймаг | Улаанбаатар хот | Оршин суугаа сум | Баянгол дүүрэг |
| Төрсөн газар | Өвөр Монгол | Төрсөн он | 1928 |
| Ажил мэргэжил | Лам | | |
| Лам байсан эсэх, Шавилан сүүж байсан сүм хийд | Шилийн гол аймгийн хуучид Хамбын сүм, Өндөр хамарын хийд, | Сүм хийдийн дугаар | СБЭЦ 001 |
| Одоогийн сүм хийд | Гандантэнгчинлэн хийд | Сүм хийдийн дугаар | УВ 01 |
| Ярилцлага авсан он сар өдөр | 2007 оны 12-р сарын 29 | Ярилцлага авсан хүн | Ч. Хулан |

Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын Өндөр хамарын хийд, Өвөр Монголын Шилийн гол аймгийн хуучид
Хамбын сүм,

Нэг л олон хийд сүмийн тухай түүж нэг ном гаргасан юм. Энд 1660 оны цагаан хулгана жил одоогийн Хэнтий аймгийн Мөрөн сумын нутагт Гүндгарвалин хийд байгуулагдав. 1733 оны харагчин үхэр жил Дорнод аймгийн Чойбалсанд Манзуширийн хийд байгуулагдав. Мөн онд Сан бэйсийн хошуу хийд болох Дашдаржайлин хийд байгуулагдав. 1735 оны хөхөгчин туулай жилд Хэнтий аймгийн Баян-Овоо суманд Баруун гуутын хийд, Жавхлантын хийд байгуулагдав. 1761 оны цагаагчин могой жил Хэнтий аймгийн Идэрмэг суманд Шаддүвчойнхорлин хийд байгуулагдав. 1765 онд Хэнтий аймгийн Баян-Овоо суманд Гэлэргавжайлин хийд байгуулагдав. 1771 онд Хэнтий аймгийн Идэрмэг суманд Үзэмтийн хийд байгуулагдав. 1868 оны шар луу жил Сүхбаатар аймгийн Баянтэрэм, Наран суманд Өндөр Майдарын хийд, Будангийн хийд тус тус байгуулагдав. 1870 онд Дорнод аймгийн Баяндун, Халх гол сумд Угтамын хийд, Халхын хошуу хийд тус тус байгуулагджээ гэх зэргээр энд оруулсан байгаа. Хэнтий аймгийн хийдүүд Гүний хийд гэж байсан. Дэчин гэгээний хийд гэж байсан. Дэчин гэгээний хийд онгоцны буудлын тэнд байсан. Хойшоо Угтамын хийд гэж байсан. Ялгуулсан хутагтын дээд, доод хүрээ гэж байсан. Доод хүрээ нь улааны, Гармагийн шашинтай. Дээд хүрээ нь гэлэгвагийн шажинтай байсан юм байна лээ. Өндөр гэгээн Төвдөөс Ганжуурын 108 ботийг залав. Энэ Ганжуур Хэнтийн Ригжий бүү хийдийн шүтээн болов.

Сан бэйсийн хоёр хүрээ Дорнод аймгийн төв дээр байсан. Нэг нь сэр чойртой, нэг нь гомон чойртой. Нэгийнх нь нэр Данригдаржайлин. Матад суманд Арын хамбын, Алтан Очиртын хийд гэж байсан. Матад сум Үйзэн бэйсийн хошуу. Дэчин гэгээн, Угтамын лам хоёр хамгийн түрүүнд баригдсан лам нар юм гэнэ лээ. Угтамын лам Довчин хувилгаан гэж байсан.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын Егүзэрийн хийд тэр хавьдаа хамгийн том нь. Тэр хавийнхаа чойртой хийд нь юм. Дарханхаанд чойртой хийд байхгүй. Уиастайн хийд гэж байсан. Яг тэр Дарханхааны өвөрт Бандидын ламын хийд гэж байсан. Тэгээд мөн Пунгийн хийд гэж байсан. Пунцаг туслагч гэдэг хүний гаргасан хийд гэнэ лээ. Тэднийхний лам нар чинь бүгд Егүзэрийн хийдэд сууж байсан лам нар. Чойрт хүрж байсан. Пунгийн хийд дээр чинь хэдэн сүрхий гавж нар байсан шүү. Баригдаад явсан. Данжай лам гэдэг чинь Дарханхааны яг өвөр дээр байгаа Ламын хийд гэж тэр чинь одоо Гончигданжий ч гэдэг, Чойжингүвийлодой ч гэдэг. Их ном хийсэн хүн. Сүмбэмтэйгээ дөрвөн боть ном хийсэн хүн. Ном нь олдохгүй болсон юм. Бар дараагүй болохоор. Чадравалын дордон хийсэн ч гэж ярьдаг. Саяхан бас нэг хүн хэдэн ном авчирч өгсөн. Тэр дотор Данжай ламын нэг ном байна лээ. Хааяа энд тэндээс ганц нэг юм олддог юм. 1949 онд намайг энд ирэхэд Эрдэнэпил хамба захиж байсан юм. Дандий ламын номноос олдвол ганц хоёрыг ч болов олж өгөөрэй гэж. Энэ сүрхий лам. Чадраабалын дордон хийгээд хэрэг гарвал миний ном хэрэгтэй. Хэрэг гарахгүй бол түлчихнэ биз гээд түлчихдэг байсан гэсэн. Дарьгангын нутгаар хуй-хуй орж ирчихээд одоо манайхныг хэзээ хэзээгүй ирж идэх нь гэсэнд Чадраабалын дордон хийгээд 3 хоног уншаад тэгээд сороо залсан чинь нөгөөдөр нь хүн давхиж ирсэн гэсэн. Хуй-хуй буцлаа гэж. Тэр сор залдаг шөнө Хуйхуйны ноён үхээд хоносон байсан. Тэгээд ноёнгүй болоод буцсан гэж. Тийм чадалтай мундаг лам байсан юм гэнэ лээ. Ном судар нь хувьсгалын үед шатаасан юм уу, ууланд хаядаг юм уу тэгээд байхгүй болсон. Дандий ламын сүмбэнд номынх нь гарчиг л байдаг.

Тэр жил Дорнод аймгийн Халх гол сумын То вангийн Их бурханыг аравнайлахад Даваасүрэн гэсгүй, Дамдин гуай бид хэд 12 хүн явсан. Тэнд 10 ханатай гэрт Чайв аравнай хурсан юм. Тэгэхэд нэг гажуу Балдан билүү, ямар Балдан билээ нэг өвгөн ирсэн. Нэг өдөр хуралд хурсан. Тэгсэн тэр хүн Халхын сүмийн хүн юм билээ. Мөн сайн мэдэж байна лээ. Аргагүй тэнд сууж байсан хүн болохоор. Залуудаа манай эндээс барга руу явж тагнуул хийж байжээ. Өөрөө түүхээ ярьж байсан юм. Олон жил тэнд суухаар амьтан сэжиглээд, тэгээд үнэмшүүлэх гэж нэг баян айлын хүүхэнтэй сууж 5, 6 жил болсон. Тэгсэн гайгүй болж өө энэ Балдан чинь манайхны хүн байж гэж. Тэгээд нэг шөнө оргоод наашаа гараад ирсэн. Сүүлд нь дахиад нэг очсон. Энэ чинь толгой хүн гээд цэргүүд хөөгөөд хурдан морьтой явж байсан. Халх гол их үертэй байсан. Хамаг юм нь нурууд айхтар сайн морьтой байсан тулдаа гараад ирсэн. Наад хөвөөнд хувцсаа тайлчихаад байж байсан. Цаанаас цэргүүд ирээд над руу буудаад байсан.

Хүрэх ч үгүй юм. Усанд шол гээд ойчоод байсан. Тэгж нутагтаа ирж байлаа гэж ярьж байсан юм.

Би Өвөрмонгол хүн. Шилийн гол аймгийн хуучид Хамбын сүмд сууж байсан хүн. Тэгээд сүүлд нь цаашаагаа Авга нарын Зүүн бэйс гэж байсан тэнд Арьяа зандан Бандидын хийдэд 14 тэйдээ очиж суусан. 18 нас хүртлээ тэд суусан бөгөөд Оросын цэрэг орж ирээд баахан амьтдыг алаад хядаад байсан. Тэндээс жигшээд бид наашаа нутаг руугаа ирсэн. Манай нутаг Чоно голын урдхан 60-аад км-т. Баруун хуучид гэдэг чинь Чоно голын урд. Хуучид Хамбын хийд хил дээр байсан хийд юм. Лхачинвандад уулын баруун урд руу манай нутаг. Лхачинвандад уул Баруун Хуучид, Егүзэрийн хошуу ван хоёрын хил байгаа юм. Тэрний баруухан урд нь манай нутаг. Тэрний баруун хойхно нь Шовдол гэж байгаа юм. Тэрний баруун талаар хоёр Түнтгэр гэж ярьдаг юм.

Энэхүү нэр дурдсан хүний аман ярилцлагын үгчилсэн тэмдэглэл нь зөвхөн ярилцагчийн хувийн мэдээллээс бүрдсэн болно.

© Монголын Урлагийн Зөвлөлийн Соёлын Өвийн Хөтөлбөр, Монголын Сүм хийдийн түүхэн товчоон

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Хоёр том уул бий. Рашаан далай булаг гэж манай нутагт ч ордог, Сэцэн ханы Төв засгийн нутагт ч ордог. Хоёулангийнх нь санд ордог юм. Рашаан далай булагийн баруухан урд Суиангийн хөндий гэж байгаа. Тэр чинь яг манай нутаг юм. Дээр үед сумангийн харуул гэж нэрлэж байсан юм гэнэ лээ. Хоёр нутгийн зааг дээр харуул байсан юм гэсэн. Тийм ойрхон байсан юм. Тэгээд л 1945 онд Баруун хуучидын гурван баг айл наашаа орж ирсэн. Хуралтай, номтойгоо ороод ирсэн. 150 гаруй лам орж ирсэн. Тэгээд 70 хэдэн лам л хүрж байсан. Өвгөн лам голдуу. Залуугаас цөөн хэдэн хүн байсан. Залуучууд нь цэрэгт яваад. Өндөр хамар гэдэг газар бий. Тэрний энгэр дээр манайх долоон жил болсон. Тэрнээсээ урагшаа сумаа дагаж нүүгээд Тохой гэдэг газар долоон жил болсон. Тэгээд яг 1960 онд би гурван машин юмтай хамаг юмаа ачиж тээгээд хотод ирсэн. Хорин хэдэн лам нараа уйлуулж орхиод. Цаанаасаа нам засаг албаар хураасан юм. Хөдөөгүүр байсан хийдүүдийг. Хөлөнбуйрт Баргын хийд гэж байсан. Баргууд Шинэ барга Зүүн хошуунаас сумаараа орж ирсэн. Ганданданжайлин гэдэг хийдтэй байсан. 1960 онд энд нийлсэн. Үзэмчинийх гэж байгаа. Сэргэлэн сум гэж Дорнодын хойт руу байгаа. Тэр Сэргэлэн суманд чинь орж ирэнгүүтээ Хэрлэнбаян сум нэртэй болоод сүүлдээ байгаад Сэргэлэн сум гэдэг болсон. Ховдын Булган суманд Шинжаанаас торгуудууд орж ирсэн. 1944 оны өвөл орж ирсэн. Булгандаа байж байгаад 1954 онд Ганданд нийлсэн. Дорноговийн хоёр хурал байсан. 1945 онд орж ирсэн. Дилав хутагтын хурал, Очирдарь ламтаны хурал гэсэн нэртэй. Дэ вангийн Дэмчигжав вангийн дэргэд байсан. Тэд хоёул орж ирээд нэг нь Дорноговийн Иххэт суманд байж байгаад 1952 онд энд нийлсэн. Нэг нь 1963 онд энд нийлсэн. Хар айрагийн хурал гэж байгаад. Энэ хурал хамгийн сүүлд нийлсэн. Ингээд Ганданд зургаан хурал нийлсэн. Энэ зургааг Гандан захирч байсан юм. Гандан анх 1944 онд Мөргөлийн дуган гэж байгуулсан. Хэдхэн хүн Улсын Бага хуралд санал өгөөд. Энэ Ганданг Орос эдэлж байсныг нь хөөж гаргаад, засаж янзлаад Мөргөлийн дуганг нээсэн юм. Тэгээд 1947 онд тэр олон хурлууд ирчихсэн.

Намын хороо, засгаас энэ олон хурлуудыг чинь бид удирдаж болохгүй. Яах вэ гээд төв хороонд мэдүүлсэн Төв хороо Ганданг ер нь төв захиргаа болгочихоё гээд Улаанбаатар хот, Гандантэгчинлэн хийд шашны төв захиргаа гэсэн тавин лангийн мөнгөн ембүүн тамгатай болгосон юм. Тэгээд хотод орж ирсэн хурлуудыг бүгдийг Гандан удирдаж эхэлсэн юм. Бид чинь бүгд Гандангийн удирдлаган дор олон жил байсан юм. Тэр хийдүүдийн лам нар хэчнээн олон хүн байсан одоо би л үлдээд байна. Ховдоос 12 лам ирсэн. Дорноговийн Зүүн хурлаас арван хэдэн лам нар ирсэн. Сүүлд 1963 онд Хар Айрагийн хурлаас 15 лам ирсэн одоо ганц ч алга. Одоо ганц Чимэддорж л байна. Үзэмчний хурлаас дөрвөн лам ирсэн. Тэд байхгүй. Баргынхаас дөрвөн лам ирсэн. Тэд бас байхгүй. Манайхаас би ганцаараа үлдээд байна. Тэр үеийн түүхийг бүгдийг би мэднэ. Энэ тухайгаа ч бичиж байгаа. Би Эрдэнэцагаан сумын хүн биш. Гэхдээ би 1990 онд Егүзэрийн хийдийг Дарханхааны ганц лам Яримпил гэж байсан тэр биднүүс тавуул нийлж сэргээсэн юм.

Хуучид Хамбын хийд 300 гаруй ламтай Манба дацантай, өөр дацан байхгүй ийм хийд байсан юм. Манба дацандаа Манлын дүлцэн, Гүнрэгийн дүлцэн хоёр хийж байсан 12,13-тай байхдаа хийлцэж байсан. Тэгээд тэрийгээ үлдээх гэж Нацагдоржийн Манба дацанд үржнэн гаргалаа. Тэднийх хоёр гурван жил хүрж байгаа. Гүмбэнд хоёр хүүхэд явуулаад та нар үзээд ир гэсэн. Дүлцэн гэдэг ямар юм байдгийг. Тэгэхгүй бол би харанхуй

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

таанууст, юу ч мэдэхгүй улсад зааж чадахгүй гэсэн. Тэгээд тэр хоёр үзэж ирээд би зааж өгөөд горимыг нь хийж өгсөн. Би бол Хуучид хамбын хийдийг нам засагтай нийлж байж юутай хийтэй нь хураасан хүн. Намын даалгавараар. Тэгээд одоо би тэрийгээ нэг хийдийг баллачихлаа, энэ их нүглийг яах вэ гэж бодоод тэгээд Хангал, Магтаалаа бол Ганданд шингээлээ гэж бодож байгаа. Харин Бадма-Ёгад шинийн хоёронд Цамба, Гүва, Дамдин гэдэг гурван сахиус, шинийн арван болгонд Хаянхирваа Ядам, Жамсрантай. 25-нд Янсан Ядам бүрэн бүтнээр нь хурдаг. Хуучид хамбынхаа дэгийг энд үлдээлээ гэж бодож байгаа. Одоо ганцхан юм үлдсэн. Манайх Гармагийн шашинтай байсан. Баруун дугандаа Гармагийнх, Зүүн дугандаа Гэлүгвагийнх хурдаг байсан. Тэрийгээ одоо энд байгуулах гээд Тайван бид хоёр нэг юм үзээд байна. Нэг дуган эхэлсэн байгаа. Энэ бол Хүрээнд байсан. Өндөр Богдын үед төвдийн дөрвөн урсгал дөрвүүл байсан. Хүрээний гучин аймгийн нэг нь Барга аймаг гэдэг нэртэй байсан. Барга аймгийн гол шүтээн нь Барнэг Гомбо, Махгал байсан юм. 1990 хэдэн онд хэд хэдэн хүн байсан. Надад тийм санаа ч байсангүй. Тэдэнтэй ярьж танилцаад тэгж байсан, ингэж байсан гэдгийг нь сонсоод л өнгөрч байж. Манайхны Хуучидын Гармахайдав гэдэг айхтар лам байсан тэр Барга аймагт зааж өгсөн юм гэсэн. Гармагийн шашин Халхад Мөнх хааны үеэс дэлгэрсэн шашин. 2-р Гарма Чойжи лам гэж байсан. Тэр хүнийг Мөнх хаан залж ирээд Гармагийн шажинтай болсон. Тэгэхэд Богд лам эндээгүй байсан. Тэр ринбүүчи 1357 онд мэндэлсэн. Тэгэхэд Төвдөд Гармагийн, Шажийн урсгал хоёр л голлож байсан. Тэгээд ер нь энд тэнд, энд тэнд хийдүүд гарсан байсан. То вангийнд байсан, Егүзэр ламынд байсан. Юм бэйсийнд байсан. Сан бэйсийнд байсан. Говийн ноён хутагтынд байсан. Хүүхэн хутагтынд байсан. Ийм түүх байна. Тэр нь тасраагүй явсаар байгаад Бага хаадын үед Хөвсгөлийн тэнд нутаглаж байсан манай хуучид Хошуунд уламжлагдсан. Дарайсун Гүдүн хаан гэж байсан. Тэрний хүү нь Түмэн засагт хан гэж байсан. Засагт хан аймаг Түмэн засагт ханы нэрээр нэрлэгдсэн. Түмэн засагт ханы төрсөн дүү Жүгдэр дайчин гэдэг хүн байсан. Тэрний үед л манайхан урагшаа нүүж очсон. 1610 хэдэн оны Өөлд Халхын дайны эхний үеэр нь шахуу л явсан. Очиход гурван Гарма нэртэй хүн толгойлж очиж байсан. Ноён нь Гармацэвээн, Хуучид хамба нь Гарматүндэв, тэрний дүү шавран гэж Гармачойжин гэж. Бидний үед байж байгаад энд ирээд л тасарсан юм. Барга аймгаас ганц хүн үлдээгүй. Хамгийн сүүлд Төв аймгийн Баян сумын хүн Батсүх гуай 1995 онд өнгөрлөө. Нэг өвгөн шаазан ваарны үйлдвэрт ажиллаж байсан их уран хүн байсан юм. Өндөр гэгээнийг шаазангаар хийсэн хүн. Манай Гандангаас Өндөр гэгээний хэвийг хоёр хоногийн хугацаатай бичгээр авч явж энэ шаазан баримлыг хийж байсан. Хоёр талаараа нийлдэг хэв. Одоо тэр номын санд байна уу үгүй юу. Би л даамал байхдаа Доржжанцан гуайг байхад номын санд хадгалуулж байсан юм. Нэрийг нь Дагвадорж гэдэг. Би тэр хүнийг танидаг юм. Их дэлгүүрээс нааш номын 3 гэж бий. Тэндээс ном аваад байж байтал Дагвадорж гуай зогсож байна. Сайн байна уу гээд наана цаана боллоо. Манайд ор гэлээ. Тэднийх Түүл рестораны баруун талын байшингийн хойшоо харсан хаалганы хамгийн зүүн талд хоёр давхарт юм. Орлоо. Ярилаа. Цай уулаа. Тэгсэн тэднийд том дэлгэмэл Гармавын гэгээн, Бэрнэг Махгал хоёр байх юм. Танай энэ бурхан чинь хаанахын бурхан бэ гэсэн чинь би чинь Барга аймгийн хүн шүү дээ. Чамайг, танайхныг Бэрнэг Махгалыг иэддэг гэж дуулсан. Судар байвал нэгийг өгөөч, Бэрнэг Махгалын судар байвал би нэг харах юмсан гэдэг юм байна. Тэгээд танилцаад Барга аймгийн чомбо байсныг нь мэдэж

Энэхүү нэр дурдсан хүний аман ярилцлагын үгчилсэн тэмдэглэл нь зөвхөн ярилцагчийн хувийн мэдээллээс бүрдсэн болно.

© Монголын Урлагийн Зөвлөлийн Соёлын Өвийн Хөтөлбөр, Монголын Сүм хийдийн түүхэн товчоон

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

авлаа. Тэгсэн сүүлд манай Гандангийн гал зууханд хормойгоо чирсэн нэг муу ядруу өвгөн Жамъян гуай гэж нэг инээсэн хүн байх. Гал зууханд боов хайраад байж байх. Боовонд сайн. Нэг орой манайд орж ирлээ. Та надад нэг Бэрнэг Махгалын судар байвал өгөөч гэнэ. Юун Бэрнэг Махгал гэсэн. Махгалын судар гэлээ. Би нэг Хангалын судар аваад өгсөн. Жаахан үзэж байгаад энэ биш гэлээ. Та ямар Махгал гээд байгаа юм гэсэнд Бэрнэг Махгал гэлээ. Та яагаад Бэрнэг Махгал мэддэг юм гэсэнд мэдэлгүй яахав би чинь Барга аймгийн үнзад байсан хүн юм чинь гэж байна. Дагвадоржийг танина уу гэсэнд танихгүй яахав тэр чинь чомбо байсан юм. Дагвадоржоос дуулаад таниас судар асууж байна гэлээ. Нэг удаа Дагвадорж гуайтай Арслантай гүүрний тэнд явж байгаад таартал 4-р сургуулийн энд манай Барга аймгийн дуган энд байсан гэж хэлж байсан. Ийм тодорхой баримттай байгаа юм аа. Тэгээд би ямар ч энийг нэг сэргээж үлдээх зорилготой байгаа хүн.

Бандид гэгээний хийд 1600 хэдэн онд байгуулагдсан. Бандид гэгээн 8 боть сүмбэмтэй хүн.

Баруун хуучид хошууны Хуучид хамбын хийд Тэндүвлин гэдэг төвд нэртэй байсан. Манжийн хаан Бин олгохдоо Соёлыг бүтээгч гэж орчуулж өгсөн. Манайхан урдаас 100 гаруй лам нар орж ирсэн тэрний 70 гаруй нь Өндөр хамарын хийдэд хурж байсан. 1960 он гэхэд 20 хэдэн ламтай болсон. Тэгээд Гандан тэр 20 хэдэн лам нараас дөрөвхөн ламыг нь авсан юм. Бусдыг нь авч болохгүй. Нэгдэлжих хөдөлгөөн 1959 онд ялаад нэгдлийн гишүүн болсон бүгдээрээ. Нэгдлийн гишүүн болсон хүнийг өөр газар шилжүүлэхэд тэр нэгдлийн бүх гишүүдийн хурлаар хэлэлцэж байж явуулах ёстой байсан. Эндээс Гандан мундагдаад нэгэнтээ хурлыг нь манайх хурааж ирж байгаа болохоор ямар ч байсан дөрвөн лам авахгүй бол болохгүй гэж авсан. Тэгээд бид дөрвөн лам энд ирсэн. Диваасамбуу, Лувсанваанчиг, Дамбапилжээ, Дамбийнямбуу гэсэн дөрвөн лам. Таван машин юмтайгаа. Манайхны хурлыг Гандантай нийлүүлсэн шалтгаан нь Хувьсгалт намын ажил үйлс явахгүй байна. Хөдөөгүүр хурал байгаа учраас хүүхдүүд сүжигт ороод байна гэж. Тэр үед Үндсэн хуулийн 89-р зүйлд БНМАУ-ын иргэн 18 нас хүрээд шашин шүтэх ба шашны эсэргүү суртлын нэвтрүүлэг хэрэгтэй гэж заасан байсан. Намаас шашин бол хар тамхи гэж үзэж байсан. Манай дээр чинь Онгоноос тэмээн тэрэгтэй олон хүн хурал хуруулна гээд очиж байдаг. Мөнххаанаас, Баяндэлгэрээс очиж байсан. Намрын цагт, хаврын цагт тариа тарих үеэр, мал төллөх үеэр ажил таслаад хурал хуруулна гээд явчихна. Хамаг юм болж байхад саад болоод байна. Энийг нэг хурааж Ганданд нийлүүлэхгүй бол бидний эсэргүү суртал нэвтрүүлгийг явуулахгүй байна. Ялангуяа залуучууд нь их очиж мөргөж байна гэж үзсэн. Манай хийдийн данс гэдэг чинь ийм зузаан данс байдаг байсан. Их олон асуулттай. Аль аймаг? Хэдэн настай? Юуны төлөө хурал хуруулж байгаа? гэсэн. Тэрийг сар бүр хураагаад Шашны зөвлөлд явуулна. Шашны зөвлөл Дотоод яаманд өгнө. Дотоод яам судалж тоог нь гаргана. 35-аас доош насны тэдэн хүн ирсэн байна энэ тэр гээд. Тэгэхээр Намын Төв хороо аймгийн намын хороонд бичиг явуулна. Танайх энэ сар суртал нэвтрүүлэг муу хийж гээд. Ийм цаг үе байсан юм аа. Нэгэнт Монгол улсыг гээд ороод ирсэн улсуудын хийдийг хамаагүй хааж болохгүй гээд Ганданд нийлүүлсэн юм байгаа юм. Манайхан чинь их олон малтай орж ирсэн. Баян Эрхий Равжаа гэдэг айл 12000 малтай, 10 гэртэй ирсэн. Тийм их ажлын хүчтэй, тийм их хөрөнгөтэй орж ирсэн хүмүүсийг чинь тогтоож авах гэж нам засгаас их анхаарч байсан. Бидэнд сайн юм их болсон.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Бид Өндөр хамарт 7 жил хурж байгаад Тохой гэдэг газарт 7 жил хураад манай хурал 1960 онд Гандантай нийлсэн. Ховдын Булган сум Шиньжанаас сумаараа нүүж ирсэн. Тэд торгууд улс байгаа юм. 13 торгууд сум байгаа тэрний Вангийн торгууд сум нь нүүж ирсэн. Жэ ринбүүчи гэж Ганданд байгаа алдартай Зонховыг тэмээн дээрээ ачаад залж ирсэн. Зонховын тэмээ гэж алдартай тэмээ байсан. Зонховын тэмээний хэрэглэл гэж тусдаа. Дайн самууны айхтар хэцүү цаг үе байсан. Тэгээд Зонховын тэмээг хаа хэвтэнэ тэнд бусад тэмээд нь хэвтдэг. Ингэж явсаар байгаад аюул осолгүй ирсэн. Мөн Үзэмчин хошууны Зүүн, Баруун хоёр багш гэж ирсэн. Дамбийжанцан гуай чинь манай энэ Ганданд байж байгаад сүүлд нас барсан. Тэр чинь Цэдэн лхарамбын хувилгаан юм. Их мундаг хүн. Цэдэн лхарамба чинь Сэрийн нэртэй хүн байсан юм. Лувсанцэдэн гэж. Их ном хийсэн хүн. Далай багш тэр жил ирэхдээ Цэдэн лхарамбын номноос хоёрыг аваад явсан. Одоо Цэдэн лхарамбыг мэддэг хүн надаас ондоо байхгүй болсон. Цэдэн лхарамбын Лагай Ламжил гэсэн Чойрт уншдаг нэртэй ном бий. Сайхан хийсэн. Мөн Лува Ламсал гэдэг ном бий.

Шилийн голын сүм хийдийн түүх гэсэн ном гарсан. Тэнд манай Баруун Хуучид хамбын хийдийн түүх тодорхой байгаа.